


БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮҮХИЙН 2022 ОНЫ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Шүүн таслах ажлын талаар:

Тус шүүх 2021 оны үлдэгдэл 64 хэрэг дээр, 2022 онд 714 нэхэмжлэл шинээр нэмж хүлээн авч нийт 778 нэхэмжлэл хүлээн авснаас 78 нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлд зааснаар хүлээн авахаас татгалзаж, 1 нэхэмжлэлийг нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй үндэслэлээр буцаан, 3 нэхэмжлэлийг нэхэмжлэгч татан авч, 10 хэргийг адил шатны шүүх рүү шилжүүлж, ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар 71 хэргийг хэрэгсэхгүй болгож, 576 хэрэг хянан шийдвэрлэн оны эцэст 36 хэргийн үлдэгдэлтэй үлдсэн байна.

647 хэрэг хянан шийдвэрлэн оны эцэст 36 хэргийн үлдэгдэлтэй үлдсэн байна.

Хүлээн авсан нэхэмжлэл, хэргийн шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулвал:



Нийт шийдвэрлэсэн 647 хэргийн 199 хэрэг буюу 30,75 хувийг шүүх хуралдаанаар, 377 хэрэг буюу 58,2 хувийг хялбаршуулсан журмаар, 71 хэрэг буюу 10,9 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.



Шийдсэн 647 хэрэг маргааныг эрх зүйн төрлөөр нь ангилвал:

Иргэний хуулиар 431, ИХШХШТХ-иар 106, Гэр бүлийн тухай хуулиар 82, Хөдөлмөрийн тухай хуулиар 6, Газрын тухай хуулиар 11, Компаний тухай хуулиар 2, Нийгмийн даатгалын тухай хуулиар 9, хэргийг тус тус хянан шийдвэрлэжээ.

Шийдвэрлэсэн хэргүүдээс: Худалдах худалдан авах, Иргэд хоорондын зээл, Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл, Улсад ажиллаж байсан байдлаа тогтоолгох, Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн хэрэг маргаан дийлэнх хувийг эзэлж байна.